ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЭЛ

Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны үндсэн үр дүнг тархаах семинар

А.АМАРБАЛ
Үндэсний статистикийн хорооны
Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга

2018.06.14

ХАМТРАГЧИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

ХҮЧИРХИЙЛЛИЙН ХЭЛБЭР:

- Бие махбодын
- Бэлгийн
- Сэтгэл зүйн (Хянах зан үйл)
- Эдийн засгийн

ХҮЧИРХИЙЛЛИЙН ХООРОНДЫН ХАМААРАЛ:

ХАМТРАГЧ: ОДООГИЙН БОЛОН ӨМНӨХ

- Нөхөр
- Хамтран амьдрагч
- Найз залуу
- Сүйт залуу
- Болзоот залуу

Дотны хамтрагч нь бизнес түнш болон бусад түнш/хамтрагчаас ялгаатай.

ХАМТРАГЧИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ





ХАМТРАГЧИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь

- Дархан-Уул – хамгийн их (41.0 %)
- Увс - хамгийн бага (22.4 %)

- Өвөрхангай – хамгийн их (19.4 %)
- Дорноговь - хамгийн бага (7.6 %)

ХҮЧИРХИЙЛЛИЙН НҮЦГЭН ҮНЭН

Бие махбодын хүчирхийлэл





Бэлгийн хүчирхийлэл





Бие махбодын хүчирхийлэл



Бэлгийн хүчирхийлэл



Насны бүлэг

БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЭЛ

Чанарын судалгаа:

Ойр дотно хамтрагчийн бие махбодын хүчирхийлэлд өртсөн тухайгаа ярихдаа 15-34 насны эмэгтэйчүүд зөөллөсөн үг болох “гар хүрэх” гэсэн үгийг хэрэглэж, нэрэлхэнгүй, ичиж, санаа нь зовонгуй өнгөөр хүчирхийллийн бодит төрхийг зөөллөн илэрхийлж байв. Харин 35-аас дээш насны эмэгтэйчүүд хүчирхийллийн нөхцөл байдал, бодит дүр төрхийг илэн далангүй ярихад бэлэн байсан бөгөөд энэхүү хандлага ялангуяа хамтрагчаасаа салсан эмэгтэйчүүдэд түлхүү ажиглагдлаа.

БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮЙЛДЛҮҮД

Хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд

- Алгадсан, юм шидсэн
- Зангидсан гараар эсвэл юмаар цохиулсан
- Түлхсэн, үснээс чирсэн

- Бүс, сураар ороолгох
- Мотоцикл, машинаар хөөсөн
- Мориор хөөж ташуурдсан

БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮЙЛДЛҮҮД

Чанарын судалгаа: Ганцаарчилсан ярилцлагад оролцсон эрэгтэй, эмэгтэйчүүдэд хамгийн их тохиолддог хүчирхийллийн төрөл бол бие махбодын хүчирхийлэл байв.

Эмэгтэй оролцогчид салсан болон хамт амьдарч буй ойр дотны хамтрагчийн зүгээс нэгэн зэрэг олон төрлийн үйлдлээр бие махбодод нь халддаг тухай өгүүлсэн. Дотны хамтрагчийн зүгээс үйлдэгдэж буй бие махбодын хүчирхийлэл нь цохих, алгадах, түлхэх, чимхэхээс эхлээд нүүрэн дээр дэвсэх, өшиглөх, шалны мод, ганжин, плитканы залгуур зэрэг гарт тааралдсан зүйл ашиглан цохих, хутга, заазуур ашиглан гэмтээх, духаараа мөргөж унагах, юм (ор, цонх, машин г.м) мөргүүлэх, үсдэж чирэх зэрэг маш олон төрлийн, харгис хэрцгий 40 гаруй төрлөөр (багцалснаар) үйлдэгддэг байна.

БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЗЭРЭГ

Дунд зэрэг

- Алгадах
- Түлхэх

Хүнд – дахин давтагдан үйлдэгдэж байвал

- Зангидсан гараар эсвэл юмаар цохих
- Үсдэж чирэх
- Өшиглөх, газраар чирэх, зодох
- Хоолой боох, юмаар түлэх
- Хутга, мэс хэрэглэх, мэс хэрэглэж айлган сүрдүүлэх
- Бүс, сураар ороолгох
- Мотоцикл, машинаар хөөх
- Мориор хөөж ташуурдах





БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЛИЙН ДАВТАМЖ

Бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн бараг тал нь олон удаа буюу 5-аас дээш удаа хүчирхийлэлд өртжээ.





БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЭЛ

Боловсролын түвшнээс үл хамааран бие махбодын хүчирхийлэлд өртөж байна.



Хамтрагчийн статусаар харахад гэрлэж байгаад салсан, тусгаарласан эмэгтэйчүүд БМХ-д их өртсөн байна.



Бие махбодын хүчирхийлэл үйлдэх болсон шалтгаан

Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн бараг гурван эмэгтэй тутмын хоёр нь (62.2%) тэдний хамтрагч архи ууж, согтуу байсан нь хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлсөн гэж хариулжээ.

Чанарын судалгаа: Эрэгтэйчүүд ихэвчлэн архидан согтуурсан үедээ эхнэр, найз охиныхоо эсрэг бие махбодын хүчирхийлэл үйлддэг байна. Ярилцлага өгсөн эмэгтэйчүүдийн ярианд "архинаас л болж байгаа юм, архи уухаараа хүнээ байдаг, архи уухаараа эхнэр, хүүхдээ алах шахдаг, архи ууж орж ирээд" гэх үгс олон удаа давтагдаж байлаа.



БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Бэлгийн хүчирхийллийг тодорхойлох

- Хүсээгүй байхад хүч хэрэглэн эсвэл айлган сүрдүүлж бэлгийн харьцаанд оруулсан.
- Хамтрагч нь яаж ч магадгүй гэж айсан учраас хүсээгүй үедээ бэлгийн харьцаанд орсон.
- Хүсээгүй байхад бэлгийн ямар нэгэн үйлдэл хийлгэж байсан.



БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮЙЛДЭЛ, ДАВТАМЖ



Эмэгтэйчүүдийн хувьд хамгийн их өртсөн бэлгийн хүчирхийллийн үйлдэл нь "айсандаа бэлгийн харьцаанд орж байсан" явдал юм.





Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэл

Хамтрагчийн үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийллийн тархалтыг олон улсад тооцох аргачлал нь тодорхой байдаг тул ОУ-ын түвшинд харьцуулагдахуйц үзүүлэлт болгон ашигладаг.



Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэл

Насны бүлэг: 40-44 насныхан хамгийн ихээр буюу тэдний 42.0 хувь нь өртжээ.



СЭТГЭЛ САНААНЫ ХҮЧИРХИЙЛЭЛ



СЭТГЭЛ САНААНЫ ХҮЧИРХИЙЛЛИЙН ДАВТАМЖ

Хамтрагчийн үйлдсэн сэтгэл санааны хүчирхийлэлд амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийн **58.8 хувь нь** уг хүчирхийлэлд олон удаа **(5-аас дээш)** өртсөн байна.

Амьдралдаа

Сүүлийн 12 сар



СЭТГЭЛ САНААНЫ ХҮЧИРХИЙЛЭЛ





ХЯНАХ ЗАН ҮЙЛ



ХЯНАХ ЗАН ҮЙЛ

Чанарын судалгаа: Өмнө нь гэр бүлтэй байсан, дагавар хүүхэдтэй эмэгтэйчүүдийг хардах явдал түлхүү ажиглагдаж байна.

Хамтрагчийн зүгээс хардаж, хянахдаа эмэгтэйчүүдийг найз нөхөд, хамт олноос нь хөндийрүүлж, гадагш харьцах (телефон утас, сошиал медиа болон бусад хэлбэрээр хүмүүстэй харилцах г.м) аргыг нь хязгаарладаг байна. Үүний улмаас эмэгтэйчүүд бие даасан байдал, эрх мэдлээ алдаж, хосуудын харьцаан дахь эрх мэдлийн тэнцвэртэй бус байдал гүнзгийрч, зарим тохиолдолд хамтрагчаас бүрэн хамааралтай болж, улмаар өөр бусад хэлбэрийн хүчирхийлэлд өртөх эрсдэл ихэсдэг байна.

ХЯНАХ ЗАН ҮЙЛ



ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ



ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ



ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Чанарын судалгаа: Хамтрагчийн зүгээс бие махбодын хүчирхийлэлд өртдөг олон эмэгтэй эдийн засгийн хувьд хамтрагчаас хамааралтай эсвэл хүчээр эдийн засгийн хамааралтай болсон байна. Эдийн засгийн хамааралтай байдал 35-аас дээш насны эмэгтэйчүүдэд түлхүү ажиглагдлаа.

Эрэгтэй хамтрагчид эмэгтэйчүүдийг өөрөөсөө хамааралтай болгож, хяналтандаа оруулахын тулд эмэгтэйчүүдийг ажил хөдөлмөр эрхлэхийг хориглож, эдийн засгийн хувьд бие даах боломжгүй болгодог байна.



ХҮЧИРХИЙЛЛИЙН АЛЬ НЭГ ХЭЛБЭРТ ӨРТСӨН БАЙДАЛ

Эрэгтэй хүнтэй дотно харилцаатай байсан/байгаа эмэгтэйчүүдийн тэн хагасаас илүү (57.9 хувь) нь амьдралынхаа туршид хамтрагчийн хүчирхийллийн аль нэг (нэг болон түүнээс олон) хэлбэрт өртөж байжээ. Хэнтий аймагт хамтрагчийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн өндөр (68.6 хувь) байна.

ХҮЧИРХИЙЛЛИЙН НҮЦГЭН ҮНЭН

ХҮЧИРХИЙЛЛИЙН АЛЬ НЭГ ХЭЛБЭРТ ӨРТСӨН БАЙДАЛ

Хамтрагчийн үйлдсэн хүчирхийллийн аль нэг хэлбэрт амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийн үзүүлэлт 30-34 насныханы бүлэгт хамгийн өндөр буюу улсын дунджаас даруй 8.0 пунктээр их байна.



ЖЕНДЭР БОЛОН ХАМТРАГЧИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХАНДЛАГА

Эмэгтэйчүүд зарим тохиолдолд нөхөр нь эхнэр/хамтрагчаа **цохих** буюу **зодох** явдал байж болно гэж үзсэн байна.

Бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 55.4% нь дараах тодорхойлолттой санал нийлжээ

Жендэрийн хэвшмэл ойлголтуудын талаарх мэдээлэл нь эмэгтэйчүүдийн гэр бүл дэх харилцааны хүлээн зөвшөөрөгдөх байдлыг илчлэн харуулж байна.

Хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэйчүүдийн бараг тал нь буюу 47.6 хувь, хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн талаас их буюу 55.4 хувь нь "Сайн эхнэр, нөхөртэйгөө санал нийлээгүй ч үгийг нь дагадаг" гэсэн ойлголттой санал нийлсэн байна.



Өөрөө мөнгө олдоггүй буюу гэртээ хүүхдээ асардаг, ямар нэг шалтгааны улмаас ажил хийж мөнгө олох боломжгүй эмэгтэйчүүд өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэхдээ төдийлөн өөртөө итгэлтэй бус, нөхөр/хамтрагчийхаа үг, санаа бодлыг дагадаг байна.

Аль төрлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцох, тооцохгүй байх талаар эрэгтэйчүүдийн хандлагыг тодруулахад:

Гэмт хэрэг гэж үзсэн нь:

- Байнга зодох
- Амь насанд нь аюул учиртал зодох
- Долгорт тохиолдсон бүх үйлдэл хуулийнхаа хувьд гэмт хэрэгт тооцогдоно
- Ажил хийлгэхгүй, гэрээс гаргахгүй байвал

Гэмт хэрэг биш гэж үзсэн нь:

- Нэгэнт гэр бүл болсон бол хүчирхийлэл гэмт хэрэг биш
- Эмэгтэйчүүд өөрсдөө болдоггүй учраас зодуулдаг. Иймд гэмт хэрэг биш, цагдаад хандах шаардлагагүй, харин ярилцах хэрэгтэй гэсэн ялгаатай хандлагууд ажиглагдав.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДАЛ, ХАМТРАГЧИЙНХАА ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ЭСЭХЭЭР



АМИА ХОРЛОХ ХҮСЭЛ БА ОРОЛДЛОГО



Чанарын судалгаа:

- *Дотно хамтрагчийнхаа хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдээс нэг нь ч эрүүл мэндийн байдлаа хэвийн гэж үзээгүй байна. Тэдгээрийн дийлэнх нь* ***толгой өвддөг, зүрхний өвчтэй болсон, даралт ихэсдэг болсон****, зарим хэсэг нь чих шуугиад ядаргаанд орсон, бөөр суналттай, бөөр өвддөг болсон, ходоодны шархтай болсон, цөөн тохиолдолд татаж унадаг болсон, хөл, гар янгинадаг болсон, элэг, ходоод, савны хавдартай болсон гэж хүчирхийллийн улмаас эрүүл мэндийн байдалд гарсан өөрчлөлтөө тодорхойлжээ.*

Хамтрагчийн үйлдсэн бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртөж, гэмтэл авсан эмэгтэйчүүд





Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн асуудал, хүчирхийлэлд өртсөн эсэхээр



Чанарын судалгаа:

- *Жирэмсэн үедээ ойр дотны хамтрагчийнхаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд цөөнгүй байсан бөгөөд зодуулсны улмаас хоёр эмэгтэй туттмын нэгнийх нь ураг зулбаж байжээ.*
- *Мөн жирэмсэлтээс урьдчилан сэргийлэх хэрэгсэл хэрэглэдэггүй, гэр бүл төлөвлөлтийн мэдлэггүйн улмаас жирэмсэлж, хүчирхийлэл, дараамтын улмаас үр хөндөлтөд орохоос аргагүйд хүрсэн тохиолдол судалгааны явцад хэд хэд таарсан гэж тайланд дурьджээ.*

Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэдэг болон хамтрагч нь жирэмслэхээс сэргийлэх арга хэрэглэхийг нь хориглодог эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хүчирхийлэлд өртсөн эсэхээр



6-12 настай хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хүүхдүүдийнхээ зан байдалд хийсэн ажиглалт



Анги улирсан болон сургууль завсардсан нэг болон түүнээс дээш хүүхэдтэй (6-12 насны) эмэгтэйчүүдийн хувь,



Хүүхдүүд нь (6-12 насны) гэрээсээ зугтсан эсэх



Хүүхдүүд нь ээжийгээ хүчирхийлэлд өртөж буйг харсан, сонссон (хэдэн удаа) гэж мэдүүлсэн эмэгтэйчүүдийн хувь

Эхчүүд хүүхэддээ хүчирхийллийг харуулахыг хүсдэггүй боловч хүүхдүүд нь харж, сонсож байгааг мэдэлгүй өнгөрөх тохиолдол байдаг

Өөрсдийн болон хамтрагчийн хүүхэд байхдаа өссөн гэр бүлийн орчинд хүчирхийлэлтэй байсан гэж мэдүүлсэн эмэгтэйчүүдийн хувь



ХҮЧИРХИЙЛЛИЙГ ДАВАН ТУУЛЖ БУЙ БАЙДАЛ

Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн дөрвөн эмэгтэй тутмын нэг буюу 26.5 хувь нь хүчирхийлэлд өртсөн тухайгаа "хэнд ч хэлээгүй" байна.

Хүчирхийлэлд өртсөн дөрвөн эмэгтэй тутмын нэг буюу 23.9 хувь нь цагдаад, арван эмэгтэй тутмын нэг буюу 13.2 хувь нь эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад, 12.5 хувь нь лам, шашны тэргүүнд ханддаг гэж хариулсан бол хамгаалах байр болон бусад тусламж, үйлчилгээний байгууллагад маш бага буюу 1.5 хүртэлх хувь нь ханджээ.

Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 43.6 хувь нь “хэн ч туслаагүй” гэж хариулсан.



Эмэгтэйчүүдийн ихэнх нь ойр дотны хамаатнаасаа тусламж авдаг байна.

Хүчирхийлэлд өртсөн гурван эмэгтэй тутмын хоёр буюу 68.7 хувь нь хүчирхийллийг тэвчих аргагүй болсны улмаас, 42.7 хувь нь бэртэл, гэмтэл авсны улмаас тусламж хүсэн ямар нэгэн байгууллага, үйлчилгээнд хандсан байна.

Дөрвөн эмэгтэй тутмын гурав нь буюу 75.4 хувь нь ямар нэгэн байгууллага, тусламж үйлчилгээнд хандаж авсан үйлчилгээндээ сэтгэл хангалуун байсан.



Үйлчилгээний төрлөөс шалтгаалан эмэгтэйчүүдийн сэтгэл ханамж ялгаатай байв.

ЗАРИМ ЭМЭГТЭЙЧҮҮД ТУСЛАМЖ ХҮСЭН ХЭН НЭГЭН ХҮН, БАЙГУУЛЛАГАД ХАНДДАГ БАЙХАД ЗАРИМ НЬ ЯАГААД ТУСЛАМЖ ХҮСДЭГГҮЙ ВЭ?

Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн ямар нэгэн байгууллага, үйлчилгээнд хандаагүй шалтгаан

- 25.9 % Гэр бүлийнх нь нэр хүнд унахаас айсан
- 10.0 % Татгалзсан / хариулаагүй
- 9.0 % Гэр бүл нь сална гэж айсан
- 20.9 % Хүчирхийлэл байдаг л зүйл /ноцтой асуудал биш/
- 9.4 % Хэнд хандахаа мэдэхгүй байсан
- 7.1 % Учирч болох аюул занал, үр дагавар /хүчирхийлэл нэмэгдэнэ/

Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн тал гаруй хувь буюу 51.2 хувь нь ямар нэгэн байдлаар гэрээ орхин явж байсан.

Дөрвөн эмэгтэй тутмын гурав нь буюу 72.4 хувь нь хүчирхийллийг тэвчих аргагүй болсон,

18.8 хувь нь бэртэл, гэмтэл авсан, 16.1 хувь нь гэрээсээ хөөгдсөний улмаас гэрээсээ явсан гэж хариулжээ.

Эмэгтэйчүүдийн 63.7 хувь нь хамтрагчийн бие махбодын хүчирхийллээс өөрийгөө хамгаалан ямар нэгэн эсэргүүцэл үзүүлсэн байна.



ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЗҮГЭЭС ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЭЛ

Ямар ч шалтгаангүйгээр хамтрагч эрэгтэйгээ цохиж, зодож байсан эсэх талаар асууж, холбогдох мэдээллийг цуглуулсан.



ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЗҮГЭЭС ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ҮЙЛДСЭН ХҮЧИРХИЙЛЭЛ

Ямар ч шалтгаангүйгээр хамтрагч эрэгтэйгээ зодож, цохисон тохиолдлын тал хувь нь (49.7 хувь) нэг удаагийн тохиолдол бол гуравны нэгээс илүү хувь нь (38.1 хувь) 2-5 удаагийн тохиолдол, 12.2 хувь нь тав ба түүнээс олон удаагийн тохиолдол байв.

БАЯРЛАЛАА

information@nso.mn
www.nso.mn
www.1212.mn